



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2023 оны 04 сарын 26 өдөр

Дугаар А/313

Булган сум

**Гүйцэтгэгчид гэрээ байгуулах  
эрх олгох тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Хуралдааны 2023 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 01 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнд тусгасан "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд усны эх үүсвэрийг бий болгох зорилгоор нуурыг нөхөн сэргээх зураг төсөв (Баяннуур сум) боловсруулах зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчээр шалгарсан "Жишиг проект" ХХК-тай 34 500 000 (гучин дөрвөн сая таван зуун мянга) төгрөгөөр гэрээ байгуулах эрхийг Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т олгосугай.

2."Жишиг проект" ХХК-ийн ажлын гүйцэтгэлд холбогдох хууль тогтоомж, гэрээний дагуу хяналт тавьж, хүлээн авах ажлыг зохион байгуулахыг Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т даалгасугай.

3.Гэрээнд заасан ажлыг холбогдох хууль, журам, стандартын дагуу гүйцэтгэж, хүлээлгэн өгөхийг "Жишиг проект" ХХК-ийн захирал (Ж.Даваажамц)-д үүрэг болгосугай.

4.Тус ажлын санхүүжилтийг холбогдох хууль тогтоомж, гэрээний дагуу Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээний сангаас санхүүжүүлэхийг нягтлан бодогч (П.Булган)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

6323910295